Цагдаагийн газрын аюулгүй байдлыг ханган зорилгоор байгууллагад орсон, гарсан иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж бүртгэхээр угтах үйлчилгээний ажилтнаар олон нийтийн цагдаа ажиллуулж, нийт 3584 иргэнийг бүртгэн нэвтрүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд Цагдаагийн удирдлагуудын өгсөн тушаалаар бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдлыг “Говь Ц-111” дохиогоор 6 удаа, утасны бэлэн

байдлыг 12 удаа, станцын бэлэн байдлыг 7 удаа шалгаж тэмдэглэл үйлдэн хоногийн рапортод тусган дарга, удирдлагуудад танилцуулсан.

Эрүүгийн цагдаагийн тасаг нь 2018 оны 3-р улирлын байдлаар иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс гэмт хэргийн шинжтэй 410 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч, 135 өргөдөл, гомдол, мэдээллийг эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж, 234 өргөдөл, гомдол, мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 24 өргөдөл, гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, одоо 17 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байгаа ба нийт шалгасан өргөдөл, гомдол, мэдээллийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэн, гомдол гаргагчид хариуг албан бичгээр 100 хувь мэдэгдэж ажилласан байна.

Тайлант хугацаанд өмнөх оны үлдэгдэл 93 хэрэг бүртгэлтийн хэрэг дээр шинээр 106 хэрэг бүртгэлтийн хэрэг нээж нийт 199 хэрэгт хэрэг бүртгэлийн ажиллагаа явуулснаас 61 хэргийг Мөрдөн байцаах тасагт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татах саналтайгаар шилжүүлж, 48 хэргийг хааж, 13 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж одоо 126 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж байна.

<u>Мөрдөн байцаах албаны чиглэлээр:</u>

Мөрдөгч нарын хийж гүйцэтгэх ажлыг “Able” программд шивүүлж, гүйцэтгэлийг нь тухай өдөрт багтаан хийлгүүлж, өдөр тутмын үйл ажиллагаанд нь программаар болон биечлэн хяналт тавьж, зөрчил дутагдлыг арилгуулан ажиллав.

Мөрдөн байцаах тасгийн дарга болон ахлах мөрдөгч, мөрдөгч нараас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 328-д заасны дагуу Мөрдөн байцаалтын 1, хэрэг бүртгэлтийн 1, гомдол мэдээллийн 1, албаны даргын даалгаврын бүртгэл 1, иргэн хуулийн этгээдээс гаргасан санал хүсэлтийн 1, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан сэжигтэн, яллагдагчийн бүртгэл 1, нийт 6 төрлийн гар бүртгэлээс гадна мэдэгдлийн бүртгэл, даалгаврын бүртгэл, Шүүх прокуророос буцсан хэргийн бүртгэл, Хугацаа сунгасан хэргийн бүртгэл зэргийг хөтлөн, шалгаж буй хэрэг материалтай биечлэн танилцаж зааварчилгаа, даалгавар өгч, Прокурорт шилжүүлж буй хэрэг, материал бүрийг хянах, мөрдөн шалгах ажиллагаанд оролцогчдын эрх нь зөрчигдөж байгаа эсэхэд хяналт тавин ажиллаж байна.

МБА-ны Дэд бөгөөд Дүн шинжилгээ, үнэлгээ, хяналт шалгалтын хэлтсийн даргын 2018.01.29-ний өдрийн 11/1-486, 2018.02.18-ны өдрийн 11/1-655 албан бичгээр ирүүлсэн үүрэг, ажлын чиглэл зэргийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, биелэлт үр дүнг тооцож, үүрэг, ажлын чиглэлийн дагуу хийж гүйцэтгэсэн ажлыг улирал бүр нэгтгэн танилцуулан ажиллав.

Тайлангийн хугацаанд Мөрдөн байцаах тасаг нь иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс харьяаллын гэмт хэргийн шинжтэй нийт 58 өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авч шалгаснаас, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан 7, хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 47, мөрдөн байцаалтын хэрэг үүсгэсэн 2, харьяаллын дагуу 1 гомдол, мэдээллийг шилжүүлж, одоо 1 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байгаа, нийт шийдвэрлэсэн өргөдөл, гомдол, мэдээллийг 100 хувь 5 хоногт нь шийдвэрлэн, гомдол гаргагчид хариуг албан бичгээр 100 хувь мэдэгдэж, нийт гомдол мэдээллийн 98.2 хувийг шийдвэрлэсэн байна.

Мөрдөн байцаах тасаг нь 75 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 20 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн, яллагдагчаар татаж, 28 хэрэг бүртгэлтийн хэргийг хаах саналтай прокурорт шилжүүлж ажилласан ба одоо 27 хэрэг бүртгэлтийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Тайлангийн хугацаанд мөрдөн байцаалтын нийт 33 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулснаас 1 хэргийг нэгтгэж, 2 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, 25 хэргийг Шүүхэд шилжүүлэх саналтай Прокурорын хяналтад шилжүүлж, одоо мөрдөн байцаалтын 5 хэргийн үлдэгдэлтэй ажиллаж байна.

Иргэд, хуулийн этгээдийн эрх ашгийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нөхөн сэргээх зорилгоор гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 3-р улиралд нийт 258736465 төгрөгний хохирол учирснаас мөрдөн шалгах ажиллагааны явцад нийт хохирлыг буюу 100 хувийг нөхөн төлүүлж ажилласан байна.

Шүүх, прокуророос 3-р улиралд нэмэлт мөрдөн байцаалтад буцсан хэрэг байхгүй байна.

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албанаас 2018 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 11/1-2310 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Түүвэр болон шалгах төлөвлөгөөний загвар”-ын дагуу мөрдөн шалгаж байгаа хэрэг бүрт мөрдөгч нараар түүвэр болон шалгах төлөвлөгөө хийлгүүлэн батлан ажилладаг ба шалгасан мөрдөн байцаалтын хэрэгт түүвэр төлөвлөгөө хийж, хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсан хэрэг бүрт шалгах төлөвлөгөө хийлгүүлж, мөрдөгч нар календарьчилсан төлөвлөгөө, өдөр тутмын тэмдэглэлийг өдөр тутам хөтөлж, батлуулж хэвшсэн.

Мөрдөн байцаах тасаг нь хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, ард иргэдийг чирэгдүүлэхгүй байхад онцгой анхаарч, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг түргэн шуурхай, гологдолгүй явуулах, өдөр тутмын хяналтыг сайжруулах зорилгоор аймгийн Прокурорын байгууллагатай хамтарсан зөвлөгөөнийг сар бүрийн эхний долоо хоногт зохион байгуулж, өнгөрсөн сард шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн талаар болон хүндрэл, бэрхшээл, алдаа, дутагдал, ололт амжилтын талаар зөвлөлдөж, алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэж, тухайн сард шийдвэрлэх хэргийн графикыг гарган ажиллаж хэвшсэн ба 2018 оны 3 дугаар улирлын байдлаар 3 удаагийн зөвлөгөөнийг зохион байгуулаад байна. Үр дүнд нь мөрдөгч нарын үйл ажиллагаатай холбоотой Прокурорын шаардлага одоогоор аваагүй, цаашид прокурорын шаардлага авахгүй байхад анхаарч удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллах байна.

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам код 701-д заасны дагуу гэмт хэргийн тоо бүртгэлийн санд хэргийн болон өргөдөл, гомдол мэдээллийг шивсэн эсэхэд хяналт тавьж, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Гэмт хэрэг, зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авах” код 202-д заасны дагуу хүлээн авч, тухай бүр мэдээллийг санд шивж оруулан, алба хаагчдын бичсэн мэдээллийг өдөр тутам хянаж, 7 хоног бүрийн “Мягмар”, “Пүрэв” гаригт Цагдаагийн газрын болон Мөрдөн байцаах албаны Мэдээлэл судалгаа, дүн шинжилгээ хариуцсан байцаагч нартай сангийн тулгалтыг хийн, зөрүүг арилгуулан ажиллаж байна.

“Эрүүгийн хэрэгт хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримт, эд зүйлийг хураан авах, хадгалах, хамгаалах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”, “Шинжилгээний объектыг шүүхийн шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журам”, “Эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”, “Хавтаст хэргийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх журам”-уудаар алба хаагч нарт 2 удаагийн сургалт зохион байгуулж эд мөрийн баримтын өрөөний галын аюулгүй байдлыг хангах зорилгоор уг өрөөнд галын хор болон галын аюулгүй ажиллагааны самбар байрлуулсан ба уг өрөөний ханыг цоолж агааржуулалтын систем хийсэн.

Цагдаагийн газраас шинжилгээний объектыг Шүүхийн шинжилгээний байгууллагад хүлээлгэн өгч, хүлээн авах талаар бүртгэл судалгаа байхгүй байгаад

анхаарч мөрдөгч нарыг шинээр бүртгэл гаргаж хөтөлж байх талаар ажлын чиглэл өгч, зохион байгуулан ажилласан. “Эрүүгийн хэрэгт хураан авсан хөрөнгө, орлого, барьцааны мөнгө, эд мөрийн баримтыг шийдвэрлэх журам”-д заасны дагуу Цагдаагийн газрын даргын тушаалаар Цагдаагийн газарт хадгалагдаж байгаа эд мөрийн баримтыг устгах комиссыг шинээр томилуулсан.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн А/05 дугаартай тушаалаар ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Эрзоригийг эд мөрийн баримтын өрөө хариуцсан алба хаагчаар томилогдон, эд мөрийн баримтын өрөөнд хадгалсан эд зүйлийг бүртгэлжүүлж, сар бүр үзлэг, тооллого хийдэг ба 3-р улиралд нийт 3 удаа үзлэг тооллого хийж ажилласан байна. Мөн 2018 оны 07 дугаар сард Эд мөрийн баримтын өрөөний үйл ажиллагааг Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хурлаар оруулж танилцуулан тайлагнасан.

Тус Цагдаагийн газрын Мөрдөн байцаах тасаг нь “Мөрдөн байцаах албаны түүхт 72 жилийн ой”, тасгийн “Нэрэмжит сарын аян”-ны хүрээнд зохион явуулах ажил арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, алба хаагч нарын сахилга ёс зүйг төлөвшүүлэх, албандаа итгэх итгэл үнэмшлийг бий болгох, ажлаа зөв хуваарилах, хэрэг мөрдөх арга барилыг дээшлүүлэх зорилгоор “Ахмад-Дунд-Залуу” 3 үеийн уулзалт зөвлөгөөн, “3х3 сагсан бөмбөг”-ийн тэмцээн, “Ширээний теннис”-ны тэмцээн, “Яг түүн шиг” шоу тэмцээн зэрэг арга хэмжээнүүдийг 2018 оны 09 дүгээр сард зохион байгуулан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг иргэд олон нийтэд эергээр сурталчлах зорилгоор ЦГ-ын болон МБТ-ийн цахим хаягт байршуулан ажиллаа.

Уг төлөвлөгөөний ЦЕГ-ын даргын 02 дугаартай албан даалгавар, “Эко 2018”, “Илрүүлэлт-Оргодол-Шийдвэрлэлт 2018” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хяналт шалгалт” хэсэгчилсэн арга хэмжээг 2018 оны 09 дүгээр сарын 24-ний өдрөөс 26-ны өдрийн хооронд зохион байгуулж, аймгийн төвд мод, модон бүтээгдэхүүнээр болон модны худалдааны үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн ажиллаж байна.

Хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэргүүдийг шалгаж шийдвэрлэх зорилгоор 2018 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд МБА-аас зохион байгуулсан “Хулгайлах гэмт хэргийн шийдвэрлэлт 2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд 1828000000108, 1829001200091, 1829001290090, 1828000840102, 201716000080 дугаартай хэргүүдэд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хуулийн анхны хугацаанд шалгаж, дээрх 5 хэргийг Шүүхэд шилжүүлэх саналтай аймгийн Прокурорын газрын хяналтад шилжүүлэн, шийдвэрлэлтийг Цагдаагийн байгууллагын нэгдсэн санд шивүүлэн хяналт тавин ажилласан байна.

Хариуцсан нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгах, эрүү, хэв журмын нөхцөл байдлыг сум, багаар нь тогтоож, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах зорилгоор гэмт хэрэг гаргах болсон шалтгаан нөхцөлийг судалж, Криминалоги судалгааны багт гарган өгч, үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийж, шалтгаан нөхцөлийг арилгуулахаар Мөрдөгчийн албан мэдэгдлийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлж, мэдэгдлийн мөрөөр хийсэн ажлын танилцуулга, тайланг авч ажилласан ба гэмт хэрэг үйлдэгдэж болзошгүй цэг, газруудын судалгааг гарган, эргүүлийн чиглэлд тусгуулан ажилласан ба нийт Шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт хүргүүлсэн 25 хэрэгт, 100 хувь мөрдөгчийн мэдэгдэл бичиж үүнээс 18 хэрэгт мэдэгдлийн хариуг хугацаанд авч, 7 хэргийн хариу авах хуулийн хугацаа дуусаагүй буюу нийт бичсэн мэдэгдлийн 72 хувьд нь хариу авч ажилласан.

Тайлангийн хугацаанд Ардын хувьсгалын 94, аймаг байгуулагдсаны 84 жилийн он баяр наадмын хамгаалалтад 2018 оны 07 дугаар сарын 04, 05, 06-ны өдрүүдэд хурдан морины хашааны хамгаалалтад, 2018 оны 08 дугаар сарын 14, 15-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн "Шигшмэл хурд 2018" хурдан морины уралдааны хамгаалалтад үүрэг гүйцэтгэж ажилласан байна.

Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:

Хэрэг бүртгэх албаны 2018 онд хүрэх түвшингийн байдлаар урьд оны дугаартай хэрэг бүртгэлтийн 6 хэрэг байснаас 5 хэргийг шийдвэрлэж 1 хэргийн үлдэгдэлтэй хэрэг бүртгэлтийн хэргийн 83.3 хувийг шийдвэрлэж, урьд оны мөрдөн байцаалтын 1 хэрэг байснаас 1 хэргийг шийдвэрлэсэн 100 хувийн шийдвэрлэлттэй байна.

2018 оны хэрэг бүртгэлтийн нийт 96 хэргээс 90 хэргийг шийдвэрлэн 6 хэргийн үлдэгдэлтэй хэргийн шийдвэрлэлт 93.7 хувьтай, мөрдөн байцаалтын 108 хэргээс 100 хэргийг шийдвэрлэж, 8 хэргийн үлдэгдэлтэй мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт 92.5 хувьтай, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэргээс хугацаа сунгасан хэрэг байхгүй бүгд 100 хувь хуулийн анхны хугацаанд шийдвэрлэгдэн шалгагдаж байгаа ба прокурор, шүүхээс буцсан хэрэг байхгүй болно.

Яллагдагч оргон зайлсан үндэслэлээр түдгэлзүүлсэн хэрэг байхгүй.

Хэрэг бүртгэх албанаас зохион явуулсан "Илрүүлэлт, Эрэн сурвалжлалт, Шийдвэрлэлт" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд болон 3 улирлын байдлаар Монгол улсын Эрүүгийн хуулийн 11 дүгээр бүлэгт заасан "Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг" гэмт хэргийг хүлээн авснаас үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй, үйлдэгдээд эзэн холбогдогч нь тодорхой боловч холбогдогч гэмт хэрэг үйлдсэн даруйдаа зугтсан "Асар" сангаар эрэн сурвалжлагдаж байсан хэргүүдэд ахлах мөрдөгч, хэсгийн төлөөлөгч \мөрдөгч\ нарт даргын зааварчилгаа хүргүүлэн үйлдэгдээд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй шөнийн цагаар Даланзадгад сумын Намуун дэлгүүрийн гадаа Гантөмөр бусдад зодуулсан хэргийг шийдвэрлэсэн үйлдэгдээд эзэн холбогдогч нь тодорхой боловч холбогдогч гэмт хэрэг үйлдсэн даруйдаа зугтсан гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдээр эрэн сурвалжлагдаж байгаа 10 хэргийн 10 этгээдээс 5 этгээдийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоон хэргийг шийдвэрлэсэн одоо үйлдэгдээд эзэн холбогдогч нь тодорхойгүй хэрэг байхгүй, 5 хэрэгт 5 этгээдийг Асар" сангаар эрэн сурвалжилж эрэн сурвалжлах ажиллагааг эрчимжүүлэн даргын даалгавар, зааварчилгааны хариуг авч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Давхардсан тоогоор 212 офицер, 128 цагдаа, олон нийтийн цагдаагийн ажилтан нар албаны автомашинтай, суурин, автомашины, гар станц, агсамжтай эргүүл, үзлэг, хяналт шалгалтад ажиллаж, 84 аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний цэг, салбарт нэгдсэн болон хамтарсан, хэсэгчилсэн хяналт шалгалт хийж, 38 хүнд хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 174 ширхэг гарын авлага материал таракаж, 507 этгээдэд 16.647.500 төгрөгөөр торгох, үүнээс бэлэн бусаар 487 этгээдэд 14.422.500 төгрөгөөр торгох, шийтгэлийн хуудсаар 23 этгээдэд 2.525.000 төгрөгөөр торгох шийтгэлийг тус хүлээлгэн, 556 тээврийн хэрэгсэл шалгаж, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 1 жолоочийг илрүүлж, 8 тээврийн хэрэгслийг түр саатуулан, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж, захиргааны зөрчил үйлдсэн 76 этгээдийг эрүүлжүүлж, 56 этгээдэд эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлж, 76 этгээдийг ар гэрт нь хүлээлгэн өгч, 15 иргэнийг ар гэрт нь хүргэн өгч ажиллалаа.

Зөрчлийн шинжтэй 32 гомдол мэдээллийг хүлээн авч, 10 гомдол мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, нэмэлт нотлох баримт бүрдүүлэх шаардлагатай 5 зөрчилд зөрчлийн хэрэг нээж, зөрчил үйлдсэн 2 этгээдэд баривчлах шийтгэл оногдуулахаар Шүүхэд шилжүүлж, 2 аж ахуйн нэгжид 700.000 төгрөгийн, 12 этгээдэд 825.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулав.

Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа 15 шатахуун түгээх станц, 18 аж ахуйн нэгж, 1 эмийн сангийн судалгааг шинэчлэн гаргаж, хяналтанд авав.

Хамгаалалт зохицуулалтын чиглэлээр: Өмнөговь аймгийн баяр, наадам болон бусад бэсрэг наадам, нийтийг хамарсан уралдаан тэмцээний үеийн хамгаалалт зохицуулалттай холбогдон гаргах тушаал, түүний хавсралтууд, хамгаалалт зохицуулалтын төлөвлөгөө зураглал, удирдамж, хөтөлбөр, томилгоог тухай бүр боловсруулан баталж, нэмэлт хүн хүч, техник, хэрэгслийг шаардлагатай тохиолдолд гэрээт харуул хамгаалалтын албадаас татан оролцуулах зэргээр зохион байгуулж, үр дүнг аймаг дахь Цагдаагийн газрын даргад албан бичгээр танилцуулав.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 108 удаагийн Шүүх хурлын хамгаалалтыг амжилттай зохион байгуулж ажиллав. УДШ-ээс хорих ял шийтгэгдсэн 1 этгээдийг аймгийн ШШГА-ны Цагдан хорих байранд хуяглан авч ирэх, Баяндалай, Ноён сумын зааг нутагт болсон иргэдийн цуглаан, аймгийн ЗДТГ-аас зохион байгуулсан “Солонгос эмч нарын нэгдсэн үзлэг”, “Элсний баяр-2018”, “Өнөд өвлөхүй урлахуй” ХХК-ний 10 жилийн ойн арга хэмжээ, 2018 оны 4-р улирлын ээлжит цэрэг татлагын арга хэмжээний үеийн хамгаалалт зохицуулалтын арга хэмжээг амжилттай зохион байгуулав.

Олон нийтийн цагдаагийн ажилтнуудын хийж гүйцэтгэсэн ажлын талаар: Иргэдийг хүлээн авах, дэг журам сахиулах томилгоот үүргийг 65 удаа 525 цаг гүйцэтгэж, эргүүлийн үүрэг гүйцэтгэх хугацаандаа 12 тээврийн хэрэгслийг шалгаж, 32 хүнд эрх зүйн зөвлөгөө өгч, нэгдсэн, хэсэгчилсэн арга хэмжээнд үүрэг гүйцэтгэж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавин, 100 гаруй аж ахуйн нэгжид байгууллагын “Албан мэдэгдэл” хүлээлгэн өгч, бичгээр баталгаа гаргуулах, 100 гаруй санамж сэрэмжлүүлэг тарааж ажиллав.

Ерөнхий болон нэгдсэн, хэсэгчилсэн, нэг бүрчилсэн ажил, арга хэмжээний талаар: Гудамж талбай, олон нийтийн газар, албан байгууллага, аж ахуйн нэгж, ахуйн хүрээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, захиргааны зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэхэд бүхий л үйл ажиллагаагаа чиглүүлж, зөрчлийн илрүүлэлт, шийдвэрлэлтийг ахиулахад чиглэгдсэн “Хичээлийн шинэ жил”, “Хэрэгжилт”, “Сэрэмжлүүлэг” хэсэгчилсэн арга хэмжээ, “Зөрчлийн илрүүлэлт” нэгдсэн хяналт шалгалтын удирдамжийг боловсруулан батлуулж, түүний дагуу төлөвлөгдсөн ажил, арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцов. Аймгийн ЗДТГ, холбогдох мэргэжлийн байгууллага, албан тушаалтнуудтай хамтран Засгийн газрын 01 дугаартай албан даалгаврын хэрэгжилтийг хангах чиглэлээр 15 байгууллагыг хамруулж, цахилгаанаас үүдэлтэй гал түймэр, гэнэтийн ослын шалтгаан нөхцөлийг арилгуулах чиглэлээр шалгалтыг гудамж талбай, олон нийтийн газруудад ил байрласан цахилгааны шугамд үзлэг хийх ажилд оролцов. ГХУС чиглэлээр 14 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, холбогдох хүмүүст зөвлөгөө анхааруулга өгөв. *Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлын талаар:* Нэг бүрчилсэн урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр хорихоос өөр төрлийн ял шийтгэлтэй 6 ялтанд хяналт тавьж, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, хувийн хэргийг баяжуулах ажлыг зохион байгуулж, 3 ялтанд холбогдох захиргааны хяналтыг зогсоов.

Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр: Архидан согтуурч эрүүлжүүлэгдсэн 50 хүнийг бүртгэл судалгаанд авч, орчиндоо түгшүүр төрүүлдэг 2 этгээдтэй уулзалт хийж, хууль зүйн болон сэтгэл заслын зөвлөгөө өгөв. Хамтарсан багийн хурлаар 1 иргэний асуудлыг хэлэлцэж, зөвлөгөө өгөв. Баривчлах шийтгэл эдэлж байгаа 21 этгээдэд "Зөрчлийн тухай хууль", "Архи, тамхины хор уршиг"-ийн талаар 3 удаагийн 3 цагийн сургалтыг зохион байгуулав. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацаа дуусан 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 8 шалгуур үзүүлэлтээр хяналт шалгалт хийж, зөвшөөрлийн хугацаа сунгуулах тодорхойлолт өгөв.

Эрүүлжүүлэгдсэн 76 этгээдийн шууд зардал болох 315400 төгрөг, баривчлах шийтгэл эдэлсэн 73 этгээдийн 3.039.840 төгрөгийг төсвийн дансанд төвлөрүүлж, санхүүгийн материалыг бүрдүүлэв.

<u>Улсын онц чухал объектын хамгаалалтын талаар:</u>

Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн объектын харуулд 24:72 цагаар 4 офицер, 5 ахлагч, ээлжийн хугацаанд 1 офицер, 1 ахлагч нийт 2 алба хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр 24 цагаар аюулгүй байдлыг хангаж хамгаалалтын үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд гүний 1,2,3,4,5 дугаар худаг, цэвэр усны нөөцийн санг 2 цаг тутамд явганаар болон машинт эргүүлийн журмаар хянаж, алба хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч, баталгаа гаргуулан гарын үсэг зуруулан ажиллаж байна.

2018 оны эхний 9 сарын байдлаар объектын 1 дүгээр цэгээр байнгын үнэмлэхтэй 190 хүн, түр үнэмлэхээр 101 хүн шалган нэвтрүүлж ажилласан бөгөөд 235 тээврийн хэрэгсэл зохих дүрэм зааврын дагуу шалган нэвтрүүлж хяналтад 876 хөдөлгөөн авч нийт 1402 хөдөлгөөнийг бүртгэн ажилласан байна.

Харуулчдын сонор сэрэмж, албан үүрэг гүйцэтгэлтийг Цагдаагийн газрын ёс журмын эргүүл, салааны захирагч нар өдөр тутам тогтмол шалгаж нэмэлт үүрэг чиглэлээр хангаж ажиллалаа.

Цэвэр усны байгууламжийн гүний 5 худагт суурилуулсан хяналтын камерыг хэвийн ажиллагаатай болгохоор шаардлага тавьж дахин засварлуулж ажилд оруулан ашиглаж байна.

<u>Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр</u>:

Монгол улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулийн хэрэгжилтийг хангах, "Аюулгүй-Амар тайван Өмнөговь", "Амгалан хот-Даланзадгад" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, зорилгоор төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. 2017 онд үйлдэгдсэн гэмт хэрэг зөрчлийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж 2018 оны аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд 24 зүйл заалтын 64 хэсэг ажлыг тусгуулсан. Төлөвлөгөөнд Цагдаагийн газраас зохион байгуулах ажилд 18 төрлийн арга хэмжээнд 16.200.000 /Арван зургаан сая хоёр зуун мянган/ төгрөгийн хөрөнгийг тусгуулсан. 5 төрлийн арга хэмжээнд 5.300.000 /Таван сая гурван зуун мянга/ төгрөг зарцуулагдсан.

Даланзадгад сумын ГХУССЗ-ийн төлөвлөгөөнд 18 төрлийн арга хэмжээнд 8.300.000 /Найман сая гурван зуун мянга/ төгрөг шийдвэрлүүлэн 2.300.000 төгрөгийг 2 төрлийн арга хэмжээнд зарцуулсан.

Даланзадгад-Мандалговь Даланзадгад-Гурвантэс, Даланзадгад-Цогтцэций, Цогтцэций-Ханбогд-Гашуунсухайт чиглэлийн улсын болон орон нутгийн авто замд хөдөлгөөнт эргүүлээр 7 авто машин 6.704.000 /зургаан сая долоон зуун дөрвөн мянга/ төгрөгийн шатахуун зарцуулсан.

Аймгийн төвийн 1, 2 дугаар баг Их-Уул, Хан-Уул, Гурвансайхан хорооллын дундуур 7 километр хатуу хучилттай авто зам шинээр барих ажлыг эхлүүлж, Дардан говь ХХК 8.8 тэрбум төгрөгөөр гүйцэтгэж байна. Замын цагдаагийн тасгаас авто замын зураг төсөлтэй танилцаж, тэмдэг тэмдэглэгээ, уулзвар гарцуудад саналаа өгч өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж байна.

Дундговь-Даланзадгад чиглэлийн 154 километр Улсын чанартай авто замыг хариуцсан “Даш зам” ХХК-тай хамтран зам тээврийн осол, хэрэг ихээр бүртгэгддэг газар /хар цэг/, авто замын эвтрэл, хайс хашлага хийх шаардлагатай огцом эргэлтийн судалгааг гарган дөрвөн хэсэг газарт 600 метр цацруулагчтай хайс хашлага 60.000.000 /жаран сая/ төгрөгөөр, эвдрэлтэй 700 м^2 авто замыг 30.000.000 /гучин сая/ төгрөгөөр засварлаж, авто зам дагуух 1140 ширхэг түмбэ /шон/ 4.200.000 төгрөгөөр будаж цацруулагчтай болгосон. Авто замын хашлага хийх ажил дууссан. Авто замын эвдрэл засварлах ажлын гүйцэтгэл 60 хувьтай явж байна. Мөн тус замд нарны энергиэр 24 цаг ажилладаг цэнхэр улаан анивчдаг спичкэн гэрэл 3 ширхэгийг худалдан авах 630.000 төгрөгийн санал, судалгааг Аймгийн Хуль зүйн хэлтэст хүргүүлэн шийдвэрлүүлж, холбогдох байгууллагад гэрэл авах захиалгаа өгсөн.

Даланзадгад сумын төв авто замын 600 метр квадрат эвдрэлийг засварлуулах төсөв хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газраар шийдвэрлүүлж 07 дугаар сарын 02, 03-ны өдрүүдэд бүрэн засварлуулсан.

Тус аймгийн төвийн авто замын босоо тэмдгүүдийг цацруулагч, гэрэл ойлгогчтой стандартын тэмдгээр солих, бүдгэрч муудсан хэвтээ тэмдэглэгээг шинэчлэх судалгааг гарган босоо тэмдэг 59 ширхэг, Улсын болон орон нутгийн зам дагуу байрлуулах хиймэл төмөр цагдаа 6 ширхэг, нарны гэрлээр 24 цагаар ажилладаг спичкэн /маяак/ гэрэл 10 ширхэгийг худалдан авахад 19.363.023 төгрөг, хэвтээ тэмдэглэгээг шинэчлэн тодруулахад зарцуулагдах 10.363.977 төгрөг, нийт 30.000.000 төгрөгийг шийдвэрлүүлэх тухай судалгаа албан бичгийг Даланзадгад сумын захирагчийн ажлын албанд хүргүүлж, 3 дугаар улирлын төсвийн тодотголоор шийдвэрлүүлсэн.

Цогтцэций сумын Засаг даргын Тамгын газар, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд мотоциклын хамгаалах малгай 300 ширхэгийг худалдан авч иргэдэд үнэ төлбөргүй тараах хүсэлтийг хүргүүлж 4.650.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн. Мөн сумын төвд тавигдах шаардлагатай 12 ширхэг тэмдгийн судалгааг гаргаж 2018 оны 06 дугаар сарын 28-ны өдөр сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргад танилцуулж 2.5 сая төгрөгийг шийдвэрлүүлсэн.

“Аюулгүй амар тайван-Өмнөговь” хөтөлбөрийн хүрээнд бага ангийн сурагчдыг зам тээврийн осолд өртөж хохирохоос урьдчилан сэргийлэх зорилгоор 3000 метрийн урттай гэрэл ойлгогчтой цацруулагч худалдан авах 1.500.000 /нэг сая таван зуун мянга/ төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Гэрээт цагдаагийн тасгаас нүүрс тээвэрлэлтийн авто замд хяналт шалгалт хийхэд шаардлагатай хурд хэмжигч худалдан авах хүсэлтийг “Гашуун сухайт авто зам” ХХК-д хүргүүлж 7.500.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн.

Мөн “Гашуун сухайт авто зам” ХХК хөдөлгөөнт эргүүлээр ажиллах 2 авто машин 4 ажилтныг өдөр бүр замын хяналт шалгалтаар ажиллуулж цагдаагийн алба хаагч нартай хамтран ажиллаж байна.

Телевизээр: Цагдаагийн газраас 2018 оны 3-р улиралд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 35 удаа, 2 цаг 35 минутын хугацаатай нэвтрүүлэг, ярилцлага, сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээллийг Алтан говь, Говийн наран, UCTV телевизүүдээр явуулж, 44 удаагийн давталттайгаар иргэд олон нийтэд хүргэсэн.

Радиогоор: Монголын үндэсний радио, Говийн долгион FM-р 2 удаа, 5 минутын хугацаатай ухуулга, сурталчилгааг 6 удаагийн давтамжтайгаар нэвтрүүлсэн.

Цахим хуудсаар: Цагдаагийн газрын цахим хуудсан дээр 2018 оны 3 дугаар улиралд гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 198 мэдээ, мэдээлэл тавигдаж, 13395 иргэн хандаж 3410 хүнд таалагдаж, 507 хүн хуваалцаж, 42 хүн сэтгэгдэл илэрхийлсэн, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг 85 удаа сурталчилсан бөгөөд 11730 хүнд таалагдаж, 610 хүн хуваалцаж, 205 хүн сэтгэгдэл илэрхийлсэн, алба хаагчийн үйл ажиллагааг сурталчлах, алдаршуулахад 15 мэдээлэл тавигдаж 365 хүнд таалагдаж, 65 хүн хуваалцаж, 42 хүн сэтгэгдэл илэрхийлсэн байна. Одоогоор Өмнөговь Цагдаагийн газар фейсбүүк хаягаар 7 мянга орчим хүн мэдээлэл авч байна.

Энэ хугацаанд цагдаагийн газраас гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зурагт хуудас 10 төрлийн 8752, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж 23 төрлийн 3500 нийт 12252 ширхгийг боловсруулан иргэд, олон нийтэд тарааж сурталчилсан байна.

Иргэд, байгууллага аж ахуйн нэгжийг татан оролцуулсан талаар: Цагдаагийн байгууллага нь 2018 оны 3-р улиралд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 дүгээр зүйл 9.1.1, 12 дугаар зүйлийн 12.1.1,12.1.2 дэх хэсэгт заасныг үндэслэн давхардсан тоогоор 182 аж ахуйн нэгж, байгууллагын 1310 ажилтан, алба хаагчдыг нийтийн эргүүлд, ажиллуулж, үр дүнг тооцсон байна.

Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн 63 дугаар зүйлийг үндэслэн 30 иргэнийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажилд олон нийтийн цагдаагаар ажиллуулж байна. Олон нийтийн цагдаа нар нь ажиллах хугацаандаа 15 зөрчил илрүүлжээ.

Мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан талаар: Энэ хугацаанд цагдаагийн байгууллагын эрх бүхий албан хаагчид нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр давхардсан тоогоор 101 төрийн байгууллага, 93 төрийн бус байгууллага, аж ахуй нэгжийг мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажилласан байна.

Одоогийн байдлаар аймгийн хэмжээнд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан өсвөрийн сэргийлэгчдийн бүлгэм 19, эцэг эхийн эргүүл ажилласан 6 сургууль, хамтарсан баг 16 үйл ажиллагаа явуулж байна. Үүнд 110 иргэн хамрагдсан ба цагдаагийн байгууллагаас дээрх бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд 3 удаа зөвлөмж өгч хамтран ажиллаж байна.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:

Тус аймгийн хэмжээнд 2018 оны 10 дугаар сарын байдлаар хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 24 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 нэгжээр буюу 20.9 хувиар өссөн. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэргийн улмаас 7 хүний амь нас хохирсон нь өмнөх оны мөн үеэс 6 нэгжээр буюу 85.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 26 алба хаагч, хот хоорондын хяналтын 5 цэгт /Цогт-Овоо, Даланзадгад, Гурвантэс, Ханбогд, Баяндалай/ болон нүүрс тээвэрлэлтийн автозамуудад 7 автомашин, 17 шалгах багаж, 6 согтуурал шалгах багаж, 6 согтуурал тандагч багаж, 5 хурд хэмжигчтэйгээр үүрэг гүйцэтгэж, тасгийн дарга, ахлах зохицуулагчаас алба хаагчдын ажлын цаг ашиглалт, эргүүл, хяналтын цэгийн хуваарьт тогтмол хяналт тавин ажиллаж байна.

“Орон нутгийн зам-Хөдөлгөөний соёл 2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд Даланзадгад сумын төвд 4 алба хаагч аймгийн төвөөс Улаанбаатар хот руу чиглэсэн улсын чанартай /А0202/ автозамын 4 дахь км-т өдрийн 11:00 цагаас орой 19:00, орой 19:00 цагаас шөнийн 02:00 цаг хүртэлх хугацаанд, Цогтцэций сумын цагдаагийн хэлтсээс 6 алба хаагч сумын төв рүү орох, гарах автозамд болон нүүрс тээвэрлэлтийн автозамын 6 дахь км-т 11:00 цагаас орой 19:00, орой 19:00 цагаас шөнийн 02:00 цаг хүртэлх хугацаанд, Ханбогд сумын цагдаагийн тасагт 1 алба хаагч сумын төвөөс орох, гарах автозамд, Гурвантэс сумын цагдаагийн тасагт 1 алба хаагч сумын төв рүү орох гарах автозам, нүүрс тээвэрлэлтийн автозам болон хил орчимд, Гэрээт цагдаагийн тасгаас 14 алба хаагч нүүрс тээвэрлэлтийн 239 км автозамыг хариуцан шалган нэвтрүүлэх цэг 1, 2, 4 дүгээр пост, “Ухаа худаг” уурхайгаас “Гашуун Сухайт” хилийн боомт хүртэлх автозамын 133 дахь км-т /Сүлжээ гэх газар/, “Оюутолгой” ХХК-ий автозамын уулзвар цэгүүдэд замын хяналт, шалгалтыг тогтмол зохион явуулж хоногт илрүүлсэн зөрчил, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээг өдөр бүр Замын цагдаагийн тасагт хаалттай мэдээ авах “Facebook” хаягаар ирүүлж ажиллаа.

Мөн Гашуун сухайтын хилийн боомт чиглэлийн хатуу хучилттай авто замд бүртгэгдэж байгаа зам тээврийн осол, хэргийг бууруулах чиглэлээр 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдрөөс Авто тээврийн үндэсний төвийн Цогтцэций салбар, “Гашуун Сухайт автозам” ХХК-тай хамтран 2 үе шаттайгаар зохион явуулж байгаа “Аюулгүй тээвэр-Хяналт” нэгдсэн арга хэмжээг эрчимжүүлэн ажиллаж улс хоорондын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийн хяналт шалгалтыг 8 удаа явуулж бүрэн бус тээврийн хэрэгсэлтэй замын хөдөлгөөнд оролцсон 5675 зөрчил илрүүлж 114.075.000 төгрөгийн торгууль оногдуулсан.

Аяны хүрээнд Улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Бяцхан зорчигч”, “Оюутан тээвэр-2”, “Хичээлийн шинэ жил”, “Ургац 2018”, “Илрүүлэлт оргодол шийдвэрлэлт” нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион явуулсан.

Тээврийн цагдаагийн албаны баталсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулагдаж байгаа календарчилсан төлөвлөгөөнд заагдсан ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах зорилгоор аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг авто сургуулиудтай хамтран ажиллах төлөвлөгөө гарган нэг авто сургууль 2 сарын хугацаанд Замын цагдаагийн тасагтай хамтран төлөвлөгөөнд заагдсан ажлыг хийж хэрэгжүүлэх аяныг эхлүүлэн ажиллаж байгаа бөгөөд “Орон нутгийн зам хөдөлгөөний соёл 2018” аяны хүрээнд авто замын эвдрэл гэмтэл, тэмдэг, тэмдэглэл, хайс хашлага, гэрлэн дохио, хяналтын камер, явган хүний гарц, гэрэлтүүлэх хэрэгсэл, рекламын самбарын

судалгаануудыг гарган эвдрэл, гэмтэл, засварлах шаардлагатай тэмдэг, тэмдэглэл, гэрэлтүүлэх хэрэгсэл, хайс хашлаганы судалгааг аймгийн Засаг даргын Тамгын газар, Даланзадгад сумын захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажилласан. Уг ажлын хүрээнд аймгийн Засаг даргын тамгын газар, Даланзадгад сумын Засаг даргын тамгын газраас шаардлагатай төсөв хөрөнгүүдийг шат дараалан шийдвэрлэж байна.

Цагдаагийн газраас “Аюулгүй тээвэр-Хяналт” “Мотоцикль бүхий өрх бүрд хамгаалах малгай”, “Хамгаалах малгай-3000”, “Нүүрс тээврийн зам хурд хяналт” нэгдсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж нэгдсэн хяналт шалгалтаар 13, хэсэгчилсэн хяналт шалгалтаар 84 удаа үүрэг гүйцэтгэж Дундговь аймаг дахь Цагдаагийн газартай хамтран 4 удаа бүсчилсэн хяналт шалгалтыг зохион явуулж тусгай зөвшөөрөлгүй нийтийн тээврийн үйлчилгээ эрхэлдэг иргэн, аж ахуйн нэгжид тавих хяналтыг эрчимжүүлэн ажилласан.

Хяналт шалгалтаар нийт 11858 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон нийт зөрчил 314 үүнээс 241 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт зааснаар хасаж 96.400.000 төгрөгөөр торгууль оногдуулсан. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй буюу эрхээ хасуулсан үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 73 иргэнийг сум дундын шүүхэд шилжүүлэн 7-30 хоногийн хугацаанд баривчлуулж, албадан сургалтад хамруулсан.

Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл жолоодсон 715 зөрчил илрүүлж 63 иргэнийг 12.900.000 төгрөгийн шийтгэврийн хуудсаар, тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон 652 иргэнд бэлэн бусаар 130.400.000 төгрөгийн торгууль оногдуулж, нийт 11481 иргэнийг бэлэн бусаар 464.723.750 төгрөгөөр торгож ажиллаа.

Арга хэмжээний хүрээнд цагдаагийн байгууллагын нийтлэг үүргээр 26 зөрчил илрүүлж, асап санд эрэн сурвалжлагдаж зарлагдсан 15-62 өво улсын дугаартай Тоёота марк-х маркийн тээврийн хэрэгслийг олж тогтоон Баянгол дүүрэг дэх Цагдаагийн хоёрдугаар хэлтсийн мөрдөгч, цагдаагийн ахмад Г.Ганзоригт хүлээлгэн өгсөн.

Мөн аян үргэлжлэх хугацаанд тус аймгийн Даланзадгад, Цогт-Овоо сумдын нутаг дэвсгэрт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цагдаагийн байнгын хяналтын пост 2 баригдахаар шийдвэрлэгдэн, пост байр барих ажлыг энэ оны 08 дугаар сарын 13-ны өдөр эхлүүлж Цагдаагийн газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс гүйцэтгэлд нь тогтмол хяналт тавин ажиллаж байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хангамжийн хэлтсийн даргын 2018 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн 6б/393 дугаартай албан бичгээр ирүүлсэн цахим хурал хийх албан бичгийн дагуу холбогдох албан тушаалтнууд 08 дугаар сарын 01-ний өдрийн 15:00 цагт цахим хуралд хамрагдаж постын барилга баригдах газрын захирамжийг 8 дугаар сарын 10-ны өдөр бэлэн болгох үүрэг өгөгдсөний дагуу Өмнөговь аймгийн Газрын харилцаа Барилга хот байгуулалтын газарт хүсэлт хүргүүлэхэд Даланзадгад сумын нутагт баригдахаар сонгогдсон Төмөртэйн овооны газар нь Зэвсэгт хүчний цэргийн ангийн бэлтгэл сургуулилт хийхэд зориулагдсан улаан шугам татсан хэсэгт хамаарагдсан тул постын газрыг дахин сонгохоор ажиллаж аймгийн төвөөс зүүн тийш 2.5 километрт дахин шинээр газар сонгож 2018 оны 08 дугаар сарын 13-ны өдөр газрын байршил тогтоох Аймгийн Засаг даргын А/907 дугаартай захирамж гарган, сонгогдсон газраас баруун тийш 200 метрт байрлах гүний усны худгаас цахилгааны эх үүсвэр авахаар Даланзадгад

сумын захирагчийн ажлын албатай тохиролцон 2018 оны 08 дугаар сарын 18-ны өдөр албан ёсоор цахилгаан холбуулсан.

Барилгын ажлыг гүйцэтгэхээр сонгогдсон “Цолмон сүндэр” ХХК нь 2018 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс суурь цутгах газраа ухаж барилгын ажлыг эхлүүлснээс хойш Замын цагдаагийн тасгаас тулгарч байгаа хүндрэл бэрхшээлүүдийг цаг тухай бүрд нь шийдвэрлэж ажилласан. Тухайлбал: 08 дугаар сарын 13-ны өдөр барилгын ажилчдыг байрлуулж амраах 20 тонны чингэлгийг тээвэрлэж байрлуулж өгсөн. 08 дугаар сарын 14-ний өдөр Даланзадгад сумын захирагчийн ажлын албатай ярилцан тохиролцож усны асуудлыг шийдвэрлэж постын газраас 200 метрийн зайнд байрлах худгаас барилгын ажилд хэрэглэх болон ажилчдад зарцуулагдах усыг үнэ төлбөргүй авч байхаар шийдвэрлэж өгсөн. Мөн 08 дугаар сарын 15-ны өдөр суурь цутгалтад хашлага хийхэд ашиглах пум, түгжээ, 6 метрийн урттай бэхэлгээний төмөр 20 ширхэг гэх мэт нэн шаардлагатай хэрэглэгдэх эд зүйл, багаж хэрэгслийг шийдвэрлэж, туслах ажилчнаар 3 хүн хоёр хоногоор ажиллуулсан зэргээр эхнээс нь үйл ажиллагаанд нь дэмжлэг, туслалцаа үзүүлэн ажиллаж байна.

Өмнөговь аймаг нь 2018 оныг бүтээн байгуулалтын жил болгон зарлаж аймгийн төвүүдээр нэлээдгүй шинэ барилга, байгууламж барьж, хуучирч муудан он удаан жил болсон барилга байгууламжийг буулгах зэрэг ажлуудыг өрнүүлж байгаагийн зэрэгцээ аймаг, орон утаг руу орж ирэх авто замд баригдаж байгаа Цагдаагийн хяналтын постын өнгө үзэмжид анхаарал тавьж, мөн орон нутгийн онцлогт тохирохгүй салхи шуурганд амархан эвдэрч, хуурч, хурц наранд гандах эрсдэлтэй нимгэн төмрөөр постын дээврийг хийж гүйцэтгэхгүй харин Оросын холбооны улсын “Росторг” ХХК-ий чанартай материалаар дээвэр хийлгэх, гадна талын өнгөлгөөний тоосгыг мөн компанийн тоосгоор өнгөлүүлэх зэрэг барилгын чанар, өнгө үзэмжийг эрхэмлэсэн постын барилга бариулах талаар гүйцэтгэгч компанитай харилцан тохиролцож, Цагдаагийн ерөнхий газраас зөвшөөрөл авч гүйцэтгүүлж байна.

<u>Бусад:</u>

Алба хаагчдын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор 2018 оны 01-р сарын 13-ны өдөр “Мөнгөн өвөл” арга хэмжээг Гурвансайхан уулын Хавцгайтын аманд зохион байгуулж, мөсний шагай, олс таталт, гир өргөлт, төмөр гинж таслах тоглоом зэргийг зохион байгууллаа.

2018 оны 03-р сарын 08-10-ны өдрүүдэд Даланзадгад цэргийн хүрээний үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулдаг “Марш тактикийн аварга” шалгаруулах тэмцээн болон спортын тэмцээн уралдаанд алба хаагчдыг бэлтгэж оролцуулав. Ахлагч бүрэлдэхүүний манлайллыг дээшлүүлэх, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор “Супер цагдаа-2018” тэмцээнийг 2018 оны 01-р сарын 10-ны өдөр зохион байгуулав. Дэд ахлагч Б.Төрболдыг Цагдаагийн ерөнхий газрын аварга шалгаруулах самбо бөхийн тэмцээнд оролцуулав.

2018 оны Цагдаагийн газрын аварга шалгаруулах теннисийн тэмцээнийг зохион байгуулав. Хэсгийн төлөөлөгч нарын сургалт, цугларалтын үеэр Эрүүгийн цагдаагийн албаны түүхт 84 жилийн ойг тохиолдуулан цагдаагийн газрын аварга шалгаруулах “Сагсан бөмбөг”-ийн тэмцээнийг зохион байгуулсан ба уг тэмцээнд төвийн тасгууд болон сумдын цагдаагийн хэлтэс тасгийн 10 баг оролцсон ба тасаг албадын дарга нар удирдлагын манлайллаа дээшлүүлж баг бүрдүүлж оролцсон. Цагдаагийн алба хаагчийн гэр бүлийн гишүүдээс “Гар бөмбөгийн аварга” шалгаруулах бооцоот тэмцээнийг 2018 оны 02-р сард зохион байгуулсан. 2018 оны 03-р сарын 13-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Цагдаагийн байгууллагын аварга шалгаруулах “Сагсан бөмбөг”-ийн

тэмцээнд эрэгтэй, эмэгтэй баг тамирчид оролцсон. Алба хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор аймгийн Спортын ордонд долоо хоног бүрийн лхагва гарагт зохион байгуулагддаг “Бүжиг суръя” арга хэмжээнд 10 удаа хамруулсан.

Цагдаагийн газрын бялдаржуулах танхимыг доод давхарт байрлаж байсныг болиулж, алба хаагчдын тохилог, тав тухтай орчинд хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн 3 давхарт шилжүүлэн тохижуулж, хуваарь гарган нэгж бүрийн алба хаагчдыг хамруулж байна. 2018 оны 05-р сарын 18-ний өдөр “Дугуйн аялал” зохион байгуулж, 2018 оны 06-р сарын 07-ны өдөр алба хаагчдаас бие бялдрын сорил авлаа.

2018 оны 06-р сарын 08-09-ний өдрүүдэд цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагуудын дунд “Хөнгөн атлетик”-ийн 2018 оны улсын аварга шалгаруулах тэмцээнийг тус аймагт зохион байгуулав.

2018 оны 09-р сард “Шилдэг хэсгийн төлөөлөгч-2018” тэмцээнийг зохион байгуулж, Ноён сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч Г.Дөлгөөн түрүүлж, улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцохоор болж бэлтгэл хангаж байна.

Цагдаагийн газрын ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх “Ахмадын баяр”-ын өдөрт зориулсан арга хэмжээг 2018 оны 10-р сарын 03-ны өдөр зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл хангаж байна.

Гурав . Дүгнэлт

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд хийх төлөвлөгөөний хүрээнд тус Цагдаагийн газраас хийхээр төлөвлөсөн ажил арга хэмжээнээс төсөв, санхүүтэй холбоотой /алба хаагчдын орон сууц барихад аймгийн Засаг даргаас 500 сая төгрөгийн дэмжлэг хүссэн, ой угтаж хийхээр төлөвлөсөн зарим нэг ажил, арга хэмжээ/ ажил, арга хэмжээнээс бусад төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдсэн болон хийгдэж байна. Огт хэрэгжээгүй тасарсан ажил, арга хэмжээ байхгүй.

Дөрөв. Санал

Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан болон гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарыг шууд Цагдаагийн газар, хэлтсийн даргын удирдлага дор байхаар бүтцэд өөрчлөлт оруулсан нь урьдчилан сэргийлэх ажилд бусад тасаг, нэгжийн дарга нараас тавих хяналт, хамтын ажиллагаа суларсан, өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах ажил орхигдоход хүрсэн зэрэг сөрөг зүйл ажиглагдаж байх тул дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн нарын ажлын цар хүрээг нэмэгдүүлэх, өдөр тутмын мэргэжлийн удирдлагаар хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор орон нутгийн Цагдаагийн газар, хэлтсийн бүтцэд Сургалт, соён гэгээрүүлэх тасаг байгуулах
2. Сургалт, соён гэгээрүүлэх тасаг байгуулах шаардлагагүй гэж үзвэл Захиргааны удирдлагын тасгийн орон тоонд оруулах гэсэн саналтай байна.

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР